

## МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТУХАЙ (XIII-XIV ЗУУН)

Д. ЭНХЦЭЦЭГ

МУИС-ийн НШУС-ийн Түүхийн Тэнхим  
e-mail: d.indra58@yahoo.com

Эмэгтэй хүн, эх хүн, үзэсгэлэн гоо, саруул ухаант бүсгүйчүүдийн үүрэг өрх гэр, төрт улс, дэлхий дахинд нэн чухал байсаар ирсэн. Түүх шашдир арвин монгол угсаатны түүхэнд “Монголчуудын зуун” хэмээн нэрлэгдсэн тэр л эрин үед дэлхийг донсолгож, гавъяат үйлсийг бүтээсэн, баатарлаг эрс олон ч тэдний ололт амжилтын үндэс болсон “түүхийг чимээгүй бүтээгч” эмэгтэйчүүд өөрсдийн орон зайгаа хэдийн эзлэн буурал түүхийн торгон хуудаснаа тэмдэглэгдэн үлджээ.



Алангоо хатны хөрөг. Турк, Истанбул

XIII-XIV зууны түүхийг бүтээгчид болох Монголчууд, ялангуяа, эмэгтэйчүүдийн талаар сонирхон судлах нь монголын түүхийн судалгааны нэг чиглэл болжээ. Бид энэ илтгэлдээ тухайн үеийн эмэгтэйчүүд ямар төрхтэй, хэрхэн харагддаг байсан болон тэдний хувцас хэрэглэл, гоёл чимэглэлийн талаар олон хэлний сурвалж бичгүүдэд хэрхэн тусгагдсан байдаг талаар өгүүлэх болно. Эмэгтэйчүүдийн төрх, өмсгөл, зүүлт зэргийн талаар “Монголын нууц товчоон”-д дурьдсан мэдээ баримт ховор ч, Юань улсын үеийн хатадын хөрөг зураг, тухайн үеийн археологийн болон антропологийн

хэрэглэгдэхүүн, хадны зураг, монгол, хятад, перс хэл дээрх сурвалжууд, өрнө дорны аялагчид жуулчдын тэмдэглэлд тулгуурлан зарим талаар нөхвөрлөн тодорхойлж болох юм.

## МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НҮҮР ЦАРАЙ, ТӨРХ БАЙДАЛ

Монгол хүний ерөнхий төрх нь дунд зэргийн нуруутай, чийрэг биетэй, өргөн нүүртэй, чамархайны доод яс нь товойсон, натвгардуу хамартай, ихэвчлэн боровтор царайтай, нарийн жартгар хэлбэртэй гялалзсан хар нүдтэй, тана мэт цагаан шүдтэй, өтгөн хар үстэй, бие нь тэвхгэр, яргай шөрмөслөг боловч туранхайдуу болно гэж тэмдэглэсэн байдаг. Францын элчин Жиованни дель Плано Карпини (1246 он) Монголчуудын “Нүүрний хэв маяг бусад хүмүүсээс ялгаатай бөлгөө. Тодруулж хэлбэл хоёр нүд нь хоорондоо зай ихтэй, шанаагаараа өргөн, хацар нь гүрийсэн булчинтай, намхан хавтгай хамартай, хөмсгөндөө хүрсэн дэрвэгэр сормуустай, онигор нүдтэй... ерөнхийдөө бэлхүүсээрээ нарийн, бараг цөмөөрөө дунд зэргийн нуруутай...” хэмээн бичжээ (Плано Карпини, 1988: 13). “Гадна байдлаараа Монгол эрэгтэй эмэгтэйчүүд онц ялгагдахгүй... адилхан урт дээлтэй боловч эмэгтэйчүүдийн нүүр царай нь өвөрмөц аятайхан үнэхээр ховорхон гоо царайлаг” (Майский, 2003: 42) ... “бараг долоон зууны тэртээхээс гадаад үндсэн төрх онцын өөрчлөгдөөгүй” гэж XX зууны үед жуулчид бичиж байв.

“Монголын нууц товчоон”-д эмэгтэй хүний тухай өгүүлэхдээ Гоо (гуа)<sup>1</sup> гэсэн үг хүний нэрийн хамт хэрэглэгдэж байгаа нь (Гоо марал, Борогчи гоо, Алан гоо) үзэсгэлэнтэй гоо сайхан гэсний илэрхийлэл болно. Мөн “өнгө зүс үзэсгэлэнтэй хатан” “зээгийн зүст, охины өнгөтэй улс, хацар гоо охид” “өнгө сайт охид”, “нүүрэндээ гэрэлтэй, нүдэндээ галтай охин” “гоо үжин”, “өнгө сайт охид хатад”, “гоо сайхан охид”, “хацар гоо хатад охид” гэж тэдний харагдах төрх, гоо үзэсгэлэнг магтсан байдаг.

Пэн Дая, Сюй Тин нарын “Хар татарын хэргийн товч”-д (1237): “... хааныг сувилагч хатад гэгч бүгд гэгээн цагаан, гуа зүстэй тэдний дөрөв нь татаар (Монгол-Д. Э) хүмүүс буюу... түүний (хааны- Д. Э) дөрвөн хатан гэдэг нь туйлын үзэсгэлэн гоо” (Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл, 1985) гэж бичжээ. Мөн жуулчдын тэмдэглэлд: “эмэгтэйчүүд ихэвчлэн цүзгэр тарган, хамар жижигхэн байх тусам хөөрхөн гэж үзнэ” (Рубрук, 1988: 119), “Эхнэрүүд магнай дээрээ шар оо (энгэсэг) түрхэж бас ч хятад хүний хуучин маягаар чимэглэж” (Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл, 1985: 137), “элдэв юм түрхэж гоёдог, хамар хөмсгөө ямар нэг түрхлэгээр түрхдэг” (Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл, 1985: 1114, 120), “эмэгтэйчүүд нь олон салаа гээг сүлжинэ, эмэгтэйчүүд хүнтэй сууж хуримласныхаа маргаашнаас эхлэн магнайныхаа шанх үсийг хяргана” (Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл, 1985: 114) гэх зэргээр XIII зууны Их Монгол улсын

<sup>1</sup> Зарим судлаачид цол хэмээн тэмдэглэсэн байдаг

үеийн эмэгтэйчүүдийн гадаад төрхийг өгүүлсэн нь хэдийгээр цөөн боловч, ховор баримт мэдээ болон үлджээ.

Мөн Гильом Де Рубрук “Мөнх хааны... хажууд залуу эхнэр сууж байв. Цирэн нэртэй ... маш царай муутай” (Рубрук, 1988: 163), Армян Мамикоян Григор ламтан (Glastyan, 1962) болон христийн шашны Томас хамбын тэмдэглэлд (Chinzorig, 2010) монгол эмэгтэйчүүдийг “царай зүс сайхан биш” гэж эсрэгээр бичсэн тал ч бий.

Монгол хатад, эмэгтэйчүүдийн ерөнхий төрх, гоёл чимэглэл, засалтыг эдүгээ Тайваны хааны ордон музейд хадгалагдан буй “Юань улсын үе улирсан хуанхугийн хөрөг”-өөс харж болно. Энд залуу, ахимаг арван таван хатны хөргийг дүрсэлжээ. Ихэвчлэн өөгүй дугуй царайтай, том хацартай, махлаг биетэй, өргөн шанаатай, ихэвчлэн жижиг хамартай, нарийвтар жартгар нүдтэй, жижигхэн амтай, хожмын монгол эмэгтэйчүүдийн түгээмэл төрхтэй ерөнхийдөө адил дүрслэгдсэн байх ч эмэгтэйчүүдийн түгээмэл хэв маяг гэж ойлгох аргагүй юм. Эдгээр зураг Юань улсын хатадын хөрөг тул монгол хүмүүс, эмэгтэйчүүдийн амьдрах хэв маягт өөрчлөлт орж, суурин амьдралын хэв маяг тод илэрдэг. Хацар, уруулыг ягаан өнгөөр будсан, нүүрэндээ тусгай түрхлэг энгэсэг түрхэн, хөмсгөө нарийхан, тэгш хэлбэртэй засаж тод хараар зуржээ. Энэ бүхэн тухайн үеийн донж маяг, эмэгтэй хүний гоо сайхны талаарх өвөрмөц үнэлэмжийг харуулж байгаа цөөн тооны, ховор түүхэн баримт дурсгал болж байна.

Их Монгол улсын үед холбогдох булшнаас олдсон хүний олдворын антропологийн судалгаагаар тухайн үеийн “монгол эмэгтэй хүний өндөр нь 156.86см, суугаа өндөр нь 84.37см, гарын урт 51.56см” гэж тооцоолон гаргасан сонирхолтой судалгааны дүн байдаг (Ванчигдаш, 2008).

## ҮС, ГЭЗЭГНИЙ ТУХАЙ

Монголын түүхийн сурвалжид тэмдэглэгдсэн “хөхөл”, “шибэлгэр” хэмээх хоёр үг дундад эртний монголчуудын гээг үсний тухай нэр болно. А.Мосторт XIII-XIV зууны үеийн монгол хаадын хөрөг зургуудыг харьцуулан үзээд “хөхөл” нь толгойн урьд хэсэг дэх урагш унжсан хэсэг үсийг нэрлэдэг үг болохыг толорхойлжээ. Хөхөл эр хүнд л байна. Шибэлгэр нь толгойн ар дахь хоёр ба хэд хэдэн салаа гээгийг нэрлэнэ. Эрэгтэй, эмэгтэй хүний аль алинд шибэлгэр байх аж. Доктор Ж.Баясах, эрдэмтэн Арданжав нар “шивэргэл бол эмэгтэй хүний үсний засал... энэ нь зөвхөн эхнэр хүний гээг ... охид бол эрд гарахаасаа өмнө үсээ хоёр хагалж нэг талдаа 4 - 6 жижиг салаа гээг болгон сүлждэг ёс Ордост одоо болтол хадгалагдан үлдсэн” (Арданжав, 1980: 100-101; Баясах, 2005:92) тухай өгүүлжээ.

Доктор Д. Баяр “Эртний монголчуудын гээг үс ерөнхийдөө адил нэг ижил хэв загвартай боловч засч янзлах арга маягийн хувьд өөр хоорондоо бага сага ялгаатай байх нь судалгааны явцад тодорхой болов. Үүнд:

- ☐ Гээгээ араас нь өөд хумин толгойн боолтонд хийн, малгайгаа өмссөн байх
- ☐ Шибэлгэрээ ганц салаа гөрж чихний араар унжуулах

- Охид бүсгүйчүүд шибэлгэрээ хоёр болон олон салаа болгон сүлжээд нэг болгон багцалж, цагираг хэлбэрээр эргүүлэн боосон харагдана. Хожмын монголчуудын дунд энэ шибэлгэр хэмээх үг ялимгүй хувирч, бүсгүй хүний үсний гэрийг нэрлэх ширэвгэр, шивэрлэг гэх болсон ба сэвгэр, сэвлэг зэрэг үгс үүнтэй утга, гарал нэгтэй бололтой юм” (Баяр, 1995: 252-255) гэжээ.

Мөн Рубрукийн тэмдэглэлд: “гэзгээ араас нь өөд хумьж нэгэн зангилаа болгож түүн дотор хийгээд малгай өмсөж сагалдаргална”, “Мөнх хааны их хатан Котата {Хутагтай} ... сүмд мөргөл үйлдэх үед толгойныхоо бокка {богтог} хэмээх гоёл зүүлтээ тайлахад түүний толгой хожгор болохыг би харсан” (Рубрук, 1988: 163) гэж бичсэнийг эс тооцвол энэ тухай өөр мэдээ ховор юм. Монголын Иль хаант улсын нэгэн зурагт, хатадын дагалт бүсгүйчүүд үсээ багцлан, хоёр талдаа цагираг хэлбэрээр дээш эргүүлэн гоёсон харагдах нь залуу охидын үс засалт бололтой. Мөн язгууртан хүний нас барахад гашуудал үйлдэж буй эмс хүүхнүүд толгой нүцгэн үс гэзгээ задалсан харагдах нь монголчуудын уламжлалт ёс эсэх нь эргэлзээтэй санагдана.

### ДЭЭЛ ХУВЦАС

Дээл хувцас нь тухайн ард түмний өвөрмөц дүр төрхийг тодорхойлдог соёлын үнэт зүйл. Түүхч эрдэмтэн Х.Нямбуу “Монгол үндэстний хувцас нь Монгол орны цаг уур, хүн ардын эрхлэн буй аж ахуйн хэв шинж, дадал зан суртал, эрхэмлэн зохицсон сэтгэцийн үнэлэмж, дээдлэн хүндэлдэг соёлын хүрээ ... нийгмийн хэв журамтайгаа нягт уялдсан онцлогтой” хэмээжээ. Хувцсанд тухайн нийгмийн болон гэр бүл, хүйсийн байдлын ялгаа тусгагдсан байдаг тул эрэгтэй, эмэгтэй, охид эхнэрийн, хүүхэд, хөгшдийн, энгийн ба ёслолын, гоёлын гэж олон ангилж болно. Мөн цаг үеийн гоо зүйн үнэлэмж, урлагийн ололт амжилт бүхнийг хувцас илэрхийлж байдаг гэж хэлж болно.

“Монголын нууц товчоон”-д гарах XIII зууны үеийн тэр олон эмэгтэйчүүд ямар дээл, хувцас, өмсгөл, зүүтгэл бүхий байсныг тоймлон гаргах нь бэрхшээлтэй хэдий ч 1221, 1237, 1246, 1250-иад он, 1280-1290-ээд оны Монголоор явж байсан өрнө дорнын элчин жуулчны тэмдэглэлийг үндэслэн нөхөн сэргээж болдог.

“Монголын нууц товчоон”-д “өөр нэртийг авбал чи Өгэлүн гэж нэрлээрэй. Амиа хоргоо. Үнэрийг минь үнэрлэж яв. хэмээн цамцаа мулталж өгөхөд”, “Бэлгүдэйн эх...навтархай нэхий дээлтэй”, “улаан дээлтэй эм хүн... Сорхон шарын охин Хадаан” (Монголын нууц товчоо, 2005: 15, 38, 54) хэмээх эмэгтэйчүүдийн хувцастай холбоотой цөөн мэдээ үлдэж хоцорсон нь Монгол эмэгтэй хүний дээл хувцасны тухай өгүүлсэн хамгийн анхны сурвалж баримт болно. Рашид ад Дины “Судрын чуулган”-д “Эрчүүдийн гол гоёл бол хөлөг морь бөгөөд Толуй хаан цайвар зүсмийн моринд дуртай... эмэгтэйчүүд хацрын энгэсэг мэт улаан өнгийн гоёлд {өмсгөл, гоёл – Д.Э} дуртай байдаг” (Рашид ад дин, 1960: 106) тухай дурдсан байдаг.

Эртний Монгол эмэгтэйчүүдийн хувцас дээл нь эрэгтэйчүүдийнхтэй адилаар ба Өмнөд Сүн улсын элч хятад элчин Чжао Хуны “Монгол татарын бүрэн тэмдэглэл” (1221он)-д “*Эмэгтэйчүүд... өргөн их ханцуйтай дээлтэй. Дундад улсын Бумбу (лам) нарын... нөмрөг шиг уужуу урт, газарт чирч, хоёр шивэгчнээр дээш өргүүлэн явумой* (Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл, 1985: 142)...” гэж өгүүлсэн нь “Монголын нууц товчоо”-ны мэдээг нөхвөрлөх чухал хэрэглэгдэхүүн болдгоороо ач холбогдолтой.

Пэн Да Я, Сюй-Тин нар (1237 он) “Хар Татарын хэргийн товч”-д: “*Тэдний хувцас хунар гэвэл, энгэрээ зүүн тийш дарж, зах нь дөрвөлжин, (хуучиндаа) эсгийгээр эсгэж, арьсан шижмээр оёдог, одоо(д)... шир утсаар үйлдэнэ. Өнгө нь улаан, бор, элгэн ногоон бөгөөд нар сар, луу гарьд тэргүүтний зурагтай, үүнд эрхэм доодсын ялгаа гэж байхгүй. Энэ нь эртний хувцастай адил ба тэдний сүүжийн дээр тоолшгүй нарийн нугалаас гаргадаг. Уужуу (том) хувцсанд бол арван хоёрхон нугалбартай*” (мөн тэнд) гэж хувцасны өнгө, хийц маяг, өнгө, нийгмийн ялгааны тухай дурьджээ.

Мөн Плано Карпини (1246 он) “*эрэгтэй нь ч тэр эмэгтэй нь ч тэр нэг л янзын оёсон дээл өмсөнө... тэд дээлээ Бухарын ноосон даавуу, ал улаан бөс буюу Багдад торго хоргойгоор дараахь маягаар хийнэ. Үүнд: дээл нь дээрээсээ аван хормойгоо хүртэл задгай, цээжин хавьдаа давхар байх бөгөөд зүүн талдаа ганц, баруун талдаа гурван товчтой зүүн ташаа нь ханцуйгаа хүртэл оноотой болой. Түүнчлэн үстэй оготор дээл (ийг) (хүрэм Д.Э) иймэрхүү янзаар хийх ба гадуур өмсөхөөр хийсэн бол үсийг нь гадагш харуулж ар тал нь задгай бас хойно тахимаа хүртэл унжсан хормойтой*” (Плано Карпини, 1988: 14) гэж бичиж үлдээжээ. Энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дээл, хүрэм ерөнхийдөө төстэй энгийн хүмүүсийн хувцасны хэв маяг адил болохыг дурьджээ. Харин “*Эрд гарсан хүүхнүүд нь урдуураа задгай энгэртэй их л өргөн, газар шүргэсэн ууж өмсөнө... бага залуу, охид, бүсгүйчүүд нь эрчүүдийн адил хувцаслана*” гэж монголчуудын хувцасны төрөл, хүйс болон насны ангилал, хийх эд зүйлийн талаар маш тодорхой тэмдэглэсэн байдаг.

Гильом Де Рубрукийн (1253 он) “Дорно этгээдэд зорчсон тэмдэглэлд” “*Тэд (Татарууд) өмсөж зүүх хувцас хунараа Хятад болон Дорно зүгийн бусад орон түүнчлэн Перс зэрэг Өрнөдийн орноос авна... тэндээс торгон ба алтан саа бүхий бөс даавуу, мөн нэхмэл эдлэл авч зун дээл хийж өмсөнө. Оросоос, Макселиэс, Их Булгари ба Паскатираас өөрөөр хэлбэл Мажараас, Керкисээс... өөрт нь алба төлдөг умар нутгийн бусад олон орноос янз бүрийн үнэ ихтэй үслэг эдлэл авчирч өвлийн хувцас хийдэг ба... өвлийн цагт ихэвчлэн хоёр дээлтэй байна. Нэг нь үсийг нь дотогш харуулан хийнэ, нэг нь үсийг нь цас салхинд гадагш харуулан хийсэн дээл (дах - Д. Э) өмсөнө. Тийм үстэй дээлээ тэд ихэвчлэн чоно ба үнэгний арьс эсхүл нохой, гөрөөсний арьсаар хийдэг. Татарууд гэртээ байхдаа арай хөнгөн өөр дээл өмсөнө... арьсаар шалбуур өмд хийнэ. Баячууд нь хувцаслахдаа - маш зөөлөн, хөнгөн, дулаан бөөн торго барьж оёно. Ядуучууд нь зузаан даавуун буюу бөс*

нэхмэл эсвэл ноолуур ялгаж тавина. “эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй адил, тэгэхдээ арай уртхан дээл өмсөнө. Эмэгтэйчүүд гэлэнмаагийн өмсгөл шиг сул өргөн... түүнээс арай урт бөгөөд өргөн, энгэр нь задгай зөв талдаа бүчилдэг дээл өмсөж ... гоёно” (Гильом де Рубрук, 1988: 113-114) гэж хувцасны хүйсийн болон улирлын ялгаа, хувцас хийх арга технологи, нийгмийн ялгаатай байдал хувцсанд хэрхэн харагдаж байсныг бичиж үлдээсэн нь сонирхолтой юм.

Өмнө дурьдсан Юань улсын хатдын хөрөг, ханын чимэг зурагт дүрсэлсэн эмэгтэйчүүд хатад баяр ёслолын үед улаан өнгийн дээл өмсөж, дээлийн энгэрийг үнэт хоргойгоор нэг өргөн, хоёр нарийн эмжсэн байдаг. Дээлийн энгэрт ямар нэг зүүлт чимэглэл зүүдэггүй байсан бололтой. Харин дагалт бүсгүйчүүдийн дээл өнгө болоод хэв маягийн хувьд бас ялгаатай харагдана. Дээл хувцасны өнгөний хувьд олон янз. Дорно дахины ард түмний адил цагаан өнгийг хүндэтгэлийн өнгө хэмээн цагаан сараар цагаан хувцас өмсөх, Гүюгийг хаан ширээнд суухад эхний өдөр монголчууд бүгд цагаан, хоёр дахь өдөр улаан, гурав дахь өдөр цэнхэр, дөрөв дэх өдөр хээ хуар бүхий алтан саатай үнэт торгон хувцас өмссөн тухай, Мөнх хааны үед дөрвөн өдрийн турш хааны өгсөн өөр өөр өнгийн гутал, дээл, малгайгаар гоёж байсан тухай өрнө дахины жуулчдын тэмдэглэлд сонирхолтой мэдээ бий.

Мөн монгол эмэгтэйчүүд олон төрлийн ажлыг хийх ба “... арьс нэхийгээр оёдол хийх ба нэхий дээлийг шөрмөсөн утсаар оёно. Тэд нарийн шөрмөсийг томж утас болгоно. Тэд оймс, гутал, дээл, хувцсыг оёно... эсгий хийж... гэрээ бүрнэ” гэж бичжээ. Марко Пологийн номд “Тэдний хувцас гэвэл баячууд нь алтан саа, магнаг торгоор хийж, өд ноолуур хийгээд булга суусар, галт хар үнэг, үнэгний арьсаар доторлосон буюу эмжиж хажсан дээл өмсөнө” (Марко Поло, 1987: 71) гэжээ. Хувцас хэрэглэлийн нэг гол хэсэг нь үнэт үслэг бөгөөд Сяо Да-Хэгийн “Монголчуудын зан суртахууны тэмдэглэл”-д (XVI зуунд): “дээлээ... барс, ирвэс, халиу, булга, минжийн арьсаар эмждэг нь: бар ирвэсний арьсаар эмжвэл шүүдэр буухад нордоггүй, булга минжийн арьсаар эмжих нь гоёлохын төлөө юм” гэж бичсэнтэй адил баримт юм.

Түүхч Х.Нямбуу, эхнэр хүний дээлний тухай “... мянган луутай ... давхар тэгш мөртэй, 72 товчтой дардгар алтан магнуг (магнаг) дээл...” (Нямбуу, 2002: 52-53), “ёслолын дээл нь цагаан торгон дээл, алтан магнаг дээл байсан” тухай тэмдэглэжээ. 1246 онд Гүюгийг хаан ширээнд залахад ирсэн ихэс ноёд “эхний өдөр цөм цагаан торгон, дараа өдөр нь улаан магнаг торгон хувцас, гурав дахь өдөр нь номин хөх торго хоргойн хувцас өмсөж байсан нь тэр цагийн ёслол хүндэтгэлийн хувцасны байдлыг харуулж байна.

Харин, *уужийг* бөс торгомсгоор хийхийн хамт арьсаар хийж (эмжиж) байсан. Зарим домог ярианаас үндэслэн Х.Нямбуу (2002) “Эртний Монгол авгайчууд хар унага, тугалын арьсан ууж өмсөж байсан” гэжээ. Иль хаант улсын

үеийн зурагт хатадын дагалт эмэгтэйчүүд дээлэн дээрээ давхар арай богино ханцуйтай ууж маягийн зүйл өмссөнөөр дүрсэлсэн байна.

Монголын нууц товчоон дахь эмэгтэйчүүдийн хувцас өмсгөлийн тухай цөөн баримт байдгийн нэг нь Бөртэ үжиний эх Чотоны (шитхүл) өмсгөл хэмээх хар *булган дахыг* “инж” болгон авсан тухай хэд хэдэн зүйлд дурьджээ (Монголын нууц товчоо, 2005: 28, 33). Мөн 114-р зүйлд Удуйд Мэргэдийн дүрвэж дутаасан хойно тэдний нутаг дээр “булган малгайтай, бугын арьсан гуталтай, булган хөөмий дээлтэй хүү” хоцорсныг, 135-р зүйлд “Татарын Нарайд шитүэний нутаг дээр орхигдсон ... алтан дөртэй ээмэг зүүсэн, ба булгаар доторлож таж торгон элгэвч (хантааз) өмссөн хүүхэд” (Монголын нууц товчоо, 2005: 49) гэх мэт балчир хүүхдийн хувцасны тухай бодитой тусгасан баримт байдаг нь XIII зууны Монголчуудын хувцасны түүхийг судлах, тэр үеийн хүмүүсийн дүр төрхийг гаргахад чухал хэрэглэгдэхүүн болж байна.

“Монголын нууц товчоо”, “Судрын чуулган” (Рашид ад дин, 1960: 55) болон бусад сурвалжуудын мэдээгээр тэр үеийн эрчүүд “бүсийг эрхэмд тооцон”, хаад, сурвалжтанууд гоёл чимэглэл бүхий: цэцгэн хээтэй, алтан товруутай “алтан бүстэй” (Монголын нууц товчоо, 2005: 39) байсан бол эмэгтэйчүүд *бүс* хэрэглэдэг байсан эсэхийг тодорхой өгүүлээгүй. Рашид-Ад-Дины “Судрын чуулган” номын чимэг зураг, Иран дахь Монголын Иль хаант улсын хаадын ордны зурагт дүрсэлснээр тэд дээлээ бүслээгүй байдаг. Эр нөхөрт гарч гэргий болмогц гэрийн үйлийг эрхлэх тул тэд бүс зүүдэггүй, иймээс тэднийг эрэгтэйчүүдээс ялгаж “бүсгүйчүүд” гэж нэрийдэх болсон болов уу?

Эмэгтэй хүн гэрийн хүн тул бүс үгүй гэж билэгдэн, эхнэр хүнд бүс бүслүүлдэггүй уламжлал тогтжээ. “Монгол түрэг хүн чулуунд аль алинд нь эмэгтэй хүнийг дүрсэлсэн боловч бүстэй дүрсэлсэн нь алга. Эмэгтэй хүний оршуулганаас бүс тийм алтан чимэглэл бүхий гардаггүй нь бүс бол эр хүний хүндэтгэл бэлгэдлийн зүйл байсны илэрхийлэл болдог” (Эрдэнэбаатар, Одбаатар, 2003: 129-132) гэж эрдэмтэн Д.Эрдэнэбаатар бичжээ.

Хэдийгээр бүс зөвхөн гоёл чимэглэл төдий бүс, нийгмийн зэрэг зиндаа, байр суурь, хүйсийн ялгааг илтгэх боловч холын аянд морь унан явах, мал ахуйгаа эрхлэн хөтлөх зэрэг гэрийн гаднах үйл эрхлэх үед эмэгтэйчүүд ч бүс бүсэлдэг байсан нь мэдээж билээ. “Монголын нууц товчоон”-д:

... Өөхийтөл богталж, огдойтол *бүсэлж*

... Годойтол богталж, өгдийтэл *бүсэлж*

.. Нятайтал богталж, нядартал *бүсэлж* Өүлэн эх, эр лүгээ адил зүтгэж, өнчин хөвгүүдээ тэжээж өсгөсөн тухай өгүүлсэн нь хожмын гэрт орж эм (бүс үгүй хүн), гадна гарч эр (бүстэй хүн) болох гэдэг зүйрлэлтэй адил юм.

Мөн Г.Рубрук “эмэгтэйчүүд морь унан давхихдаа хөх торгон бүс бүсэлдэг” гэж тэмдэглэснээс үзвэл тэд эрэгтэйчүүдийнхээс ялгаатай даавуу, торгон энгийн бүс бүсэлдэг, “хүүхдийн, эмэгтэйчүүдийн бүс” гэж байжээ. Пэн Да Я, Сюй-Тин нар “Хар Татарын хэргийн товч” (1237он) -д: “Бас улаан бор өдөнг нийтгээд дээс

*болгож бүслэхээ бүс гэнэ. Лав морины дээр биеэ чанга бүслээд довтлуулахад гоёмсог сайхан харагдахыг болсон юм*” (Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл, 1985: 142) гэжээ. “Тэр үеийн монголчууд торго дурдангаар бүс хийн бэлхүүсээрээ сайтар (чанга) бүсэлдэг байсан нь хатуу эмээл сандайлан алс замд морь унаж явахад корсет мэт хамгаалалт” (Викторова, 1980: 36) болж байв.

Энэ бүхнээс үзвэл эмэгтэйчүүд бүс огт хэрэглэдэггүй байсан мэт туйлширч ойлгож болохгүй. Бүстэй холбоотой эрхэм ёс, “эхнэр хүн бүсгүй нөмгөн айлд орох” зэргийг цээрлэх зан үйл эртнээс уламжилсан соёл тул эмэгтэй хүнд ч бас хамаатай юм.

### ТОЛГОЙН ӨМСГӨЛ, МАЛГАЙ

Монголчуудын уламжлалт малгай нь хоёр янз байжээ. Үүний нэг нь толгой боох ороолт {алчуур}, нөгөө нь малгай. Энэхүү ороолтоор эр эмгүй толгойгоо боож, хоёр үзүүрийг нь ардаа цацаглаж унжуулдаг ... өвлийн цагт булганы арьс хурганы арьсаар ороодог ба үнэгний арьсаар ч бас ороож байв. Эрэгтэйчүүд нь “намхан пүмбэгэр оройтой тойруулган малгай”... эмэгтэйчүүд нь **богтаг** хэмээх өндөр малгай өмсөж байжээ (Нямбуу, 2002: 56).

Дэлхийн олон ард түмний дунд чухамхүү “Монголын” хэмээн тодотгодог хувцас заслын онцгой нэгэн зүйл бол тэр үеийн монгол эхнэр хүний өмсөж байсан богтаг хэмээх өвөрмөц сонин малгай билээ. Монгол эхнэр хүний богтаг малгайн тухай “Монголын нууц товчоо” болон монгол нутагт ирж байсан өрнө, дорнын элчин жуулчдын тэмдэглэлд цөөнгүй дурдагджээ. Эрдэмтэн З.Батсайхан “Монгол эхнэрийн богтаг малгай” өгүүлэл, доктор У.Эрдэнэбат “Монгол эхнэрийн богтаг малгай” зохиолдоо холбогдох сурвалж мэдээ, дүрслэх урлаг, археологийн судалгааны хэрэглэгдэхүүн, судалгааны бүтээлүүдийг ашиглан тун сонирхолтой бүтээлийг нийтлүүлжээ. “Монголын нууц товчоон”-д:

*Өүлэн эх мэргэн төрж*

*Өчүүхэн хөвгүүдээ тэжээж*

*Өхийтэл **богталж**, огдойтол бүсэлж*

*Онон мөрний өөд уруу гүйж*

*Олирс, мойлс түүж*

*Өдөр шөнө хооллон тэжээв* (Монголын нууц товчоо, 2005: 22)

*...Эх тань ... горойтол **богталж**, өгтийтэл бүсэлж*

*Нятайтал **богтолж**, нядартал бүсэлж, ... эгэмнээс чинь татаж* (Монголын нууц товчоо, 2005: 134)... *эрлүүгээ сацуу босгох(в)* хэмээн өгүүлсэн зүйлд Өүлэн эх “Богтаг” өмсөж явсныг өгүүлсэн байдаг тухай судлаач У.Эрдэнэбат (2005: 96) тэмдэглэжээ.

**Богтаг** хэмээх үг нь өнөө хүртэл монгол хэлэнд байх хуримлах зан үйлийн “богтлох” гэдэг үгтэй шууд холбоотой бөгөөд, эрдэмтэн Д.Баяр (1995), У.Эрдэнэбат нарын тэмдэглэснээр уг малгайг эрт үеэс зөвхөн нөхөрт гарч хуримласан эмэгтэй хүн өмсөж байсан ёс заншлаас улбаалан “ёс төртэй гэрлэсэн”,

“богтаг толгойдоо өмссөн эмэгтэй” гэж нэрлэхтэй холбоотой юм. Иймд “богтаг” гэсэн үг “богтлох” гэсэн үгнээс үүдэлтэй бололтой. “...Богтаг хэмээх нь хууль ёсоор богтолж авсан эхнэр хүний өмсөх малгай аж...” (Эрдэнэбат, 2005: 96) гэжээ. Доктор Ж.Баясах “Европын элч нарын бичсэнээс үзвэл эрд гарсан эмэгтэйчүүдийн малгайд хоёр зүйлийн өөрчлөлт гарчээ. Нэгдүгээрт, барилгын дөрвөлжин орой мэт суурьтай болсон, хоёрдугаарт, өвлийн цагт малгай дээрээ үсэн гадар углах болж мөрлүүгээ шүргүүлдэг болжээ... орчин цагийн хэлэнд богтлох гэсэн үг байдаг нь “богто өмсүүлэх” буюу эрд гаргана хэмээсэн утгатай” гэж тэмдэглэжээ (Баясах, 2005: 86).

XIII-XIV зууны үед монгол нутгаар явсан өрнө, дорнын элчин жуулчдын тэмдэглэлд “тэр үеийн монгол эхнэр хүний” малгайг маш өвөрмөц сонин өөр ард түмэнд огт өмсөж байгаагүй болохыг онцолж “өндөр горзгор оройтой малгай” өмсөж байсныг тэмдэглэсэн байдаг. Өмнөд Сүн Улсын элчин Чжао Хун (1221): “*Эрхтэн, түрүүчүүдийн эхнэрүүд нь гү-гү (гө. гө) (гүгүл)... малгайтай. Үүнийг төмөр утсаар (хулс), (сүвэлж) гурван тохой хэр өндөр болгоно. Улаан хөх хэмэрлиг хатгамал торго буюу эсвэл сувд алтаар чимэглэж, оройд нь бас нэг нарийн мод хатгаад үүнийг бас улаан хөх өнгөт өдөөр чимэглэнэ*” (Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл, 1985: 142) гэжээ.

Мөн “Чан чун бумба баруун газар зорчсон тэмдэглэлд” (1222-1225): “*эхнэрүүд үйс (хус модны хальс)-ээр малгай хийнэ. Бараг хоёр тохой өндөр, ердэген хариши бээр бүрхээд, баячууд бас улаан дурданаар гадарлаж, түүний оройг галуу, нугасны хэлбэртэй болгодог. Үүнийг гү гү хэмээн дуудна. Үүнд бусдын гар хүрэхийг туйлаар цээрлэнэ. Өргөө гэрт орж, гарахдаа эрхбиш дорогш бөхийх хэрэгтэй*” гэж тэмдэглэжээ.

Өмнөд Сүн Улсын элчин Пэн дая, Сүй-тин нар “Хар Татарын эргийн товчид” (1237) “... *тэдний малгай .. эмэгтэйчүүд гү гү (гүгү-малгай) зүүмөй*” Сюй Тин би гү- гү хийх аргыг үзэв. Зурагт (?) модоор яс болгож, гадуур нь улаан өгөдөн хийгээд шар торгоор бүрхээд, малгайн оройд нь дөрөв таван тохой... *давтсан төмрийг хатгаж гадуур нь хөх эсгийгээр ороомой. Эрхэм хүмүүс бас манай улсын оюу цэцэг буюу эсвэл таван өнгийн торгоор чимэглэж түүнийг намилзуулан хийсгэмөй. Дорд (ард) бол гургуулийн өдийг хэрэглэнэ*” (Богдбаатар биеэр дайлсан тэмдэглэл, 1985: 177) гэжээ.

Өрнө зүгийн элчин нарын тэмдэглэлд дээрхтэй адил зүйл тэмдэглэгдсэн бөгөөд Плано Карпини: “Эрд гарсан хүүхнүүд нь толгой дээрээ дугуй богтаг хэмээх нэгэн зүйл малгай тавина. Энэ малгайг уртаашаа нэг тохой орчим саваа буюу холтсоор зүүж хийх агаад дээшээ дөрвөлжилж, доошоо өрөгсөх бөгөөд оройд нь нарийхан алт, мөнгө буюу модон савх эсвэл өд хатгана. Энэ богтагийг мөрөө хүрсэн шилэвчтэй малгайн дээр бөхөлнө... Бухар даавуу эсвэл ал улаан бөс буюу Багдад торго хоргойгоор өнгөлнө. Эхнэрүүд ийм богтаггүйгээр хүний өмнө гарна гэж байхгүй бөгөөд түүгээр нь бусад бүсгүйчүүдээс ялгаж таних ажгуу. Бага

залуу охид, бүсгүйчүүд нь эрэгтэйчүүдийн нэгэн адил хувцаслах тул таньж ялгахад бэрх. Монголчуудын малгай нь бусад хүн ардын өмсдөгөөс өөр болохоор сайтар дүрслэн бичихэд бидний чадвар мөхөсдмүй” (Плано Карпини, 1988: 14) гэсэн бол В.Рубрук: “Эмэгтэйчүүд нь Богтаг хэмээх толгойн боолт зүүж гоёно. Энэ нь модны холтос буюу өөр ямар нэг хөнгөн эдээр хийж торгоор чимсэн тэвэр хэртэй бүдүүн, тохой илүү урт болно. Түүний хөвөө дөрвөлжин агаад үзүүрт нь шувууны өд буюу ургамлын иш цухуйлган уяж дээр нь тогосын өд хатган, нугасны өд, эрдэнийн чулуугаар чимэглэнэ. Толгойн боолт дотроо хөндий. Гарсан гэзгээ араас нь өөд хумьж нэгэн зангилаа болгож түүн дотор хийгээд малгай өмсөж сагалдаргална. Тийнхүү толгойн боолттой морь унаж яваа олон хатдыг алсаас харахад дуулга өмсөж, жад гозолзуулсан цэрэг мэт харагдана” (Рубрук, 1988: 114) гэж маш тодорхой тэмдэглэж үлдээжээ.

Мөн Монгол эзэнт гүрний харьяанд байсан нэг салбар улс Алтан ордны хааны хатад ч тухайлбал, Узбек хааны хатад үнэт эрдэнийн чулуугаар чимэглэж хийсэн, дээр нь тогосын өд хатгасан бугтак (bughtag) гэдэг титэм өмсөж байсныг Арабын жуулчин Ибн Батута (Эрдэнэбат, 2005: 13) нүдээр үзэж тэмдэглэсэн байна.

Цагаадайн хааны улсад Доголонтөмөрийн ордонд богтог малгай байсан тухай (1404) Испани элчин Гуй Гонсалес Де Клавихо: *“нүүрэндээ хөнгөн нимгэн цагаан алчуураар халх хийж, толгойдоо байлдах гэж байгаа юм шиг улаан бөс даавуугаар өнгөлсөн дуулга шиг малгай өмссөн. Тэр даавуу нь түүний мөр даван унжиж байв... Энэхүү дуулга маш өндөр бөгөөд тун гоёмсог сайхан шигтгэсэн том том гэрэлтсэн дугуй сувд, бадмаараг, оюу болон бусад эрдэнийн чулуун шигтгээтэй. Дал мөр рүү унжсан шилэвч нь бас алтан утсаар хатгамалсан бөгөөд дээр нь маш сайхан цэцгэн эрхийг алтаар гөрж, эрдэнийн чулуу ба том том сувдаар чимэглэжээ. Бүгдийнх нь орой дээр өд хатгасны зарим нь доош унжсан тэр нь тохой хэрийн урт байдаг”* гэж бичсэн нь цөм нэгэн адил тэмдэглэгдэн үлджээ. Дээр дурдсан сурвалж бичгийн мэдээг баталж болох археологийн дурсгал, уран зураг үлдэж хоцорсон нь нэн сонирхолтой юм.

Судлаач У. Эрдэнэбат Монгол Улсын Их тэнгэрийн хадны зураг, БНХАУ-ын Шинжаан Уйгур болон Ганьсу мужийн агуйн ба сүмийн зургууд, Их зуу аймгийн Эзэн хорооны тахилын сүмийн зургууд, Солонгосоос олдсон зургууд, Юань Улсын үеийн хаан, хатадын хөрөг зураг, Рашид-Ад-Дины “Судрын чуулган” номын чимэг зураг, Ираны ордны зураг дахь “богтаг”-ын зургуудыг харьцуулан судалж чулуун хөшөө, булшны хэрэглэгдэхүүнд тулгуурлан богтаг малгайн уг сурвалж, түүнийг өмсөхтэй холбоотой ёс заншлын талаар үлэмж сонирхолтой дүгнэлтүүдийг хийжээ. Рашид-Ад-Дины “Судрын чуулган” номын чимэг зураг, Ираны ордны зураг дахь хатад эхнэрүүдийн дагалт бүсгүйчүүд, охид, шивэгчид богтаг малгай өмсөөгүй байгаагаас үзвэл монгол эмэгтэйчүүдийн богтаг малгай буюу Хятадуудын “гү- гү” нь ихэс дээдсийн хатад “эхнэр” хүмүүн өмсдөг, хөрөнгө хэмжээний ялгааг илэрхийлдэг, гоёмсог толгойн хэрэгсэл байсан гэж хэлж болно.

Мөн маралын годонгоор хийсэн *гумал*, үхрийн зооны ширээр хийсэн тун сайхан, сайн чанарын гутал үйлддэг байсан тухай мэдээ бий. Ад-Дины “Судрын чуулган” номын чимэг зураг, Ираны ордны зурагт хатадын хар арьсан, шөвгөр хоншоортой, гоёмсог гутал бас дүрслэгдсэн нь цухуйж харгадана.

## МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ГОЁЛ ЧИМЭГЛЭЛИЙН ТУХАЙ

Гоёл чимэглэл нь ард түмнүүдийн соёлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг байдаг. Монгол эмэгтэйчүүдийн гоёл чимэглэл нь зан үйлийн өвөрмөц ёс, аюулаас хамгаалах ид шидийн болон гоо сайхны хэрэгцээ, билэгдлийн шинжтэй ч хувцасны нэг чухал хэсэг болж уламжлан ирсэн түүхтэй.

Гоёл чимэглэл нь материал, хэлбэр хийц, хийх арга, зориулалт үнэ цэнээрээ ялгаатай. Эмэгтэйчүүдийн гоёл чимэглэлийг толгойн, нүүрний, хүзүүний, энгэрийн, гарын гэж олон төрөлд хувааж үзэж болно. Эмэгтэй хүний гоёл чимэглэл бол урлаг юм. Ээмэг, бөгж, зүүлт, унжлага, бугуйвч, үсний чимэглэл хавчаар гээд олон арван төрөл болно. Монголын нууц товчоонд энэ тухай тодорхой тэмдэглэгдэн үлдсэнгүй бололтой.

Рашид Ад-Дины “Судрын чуулган”-д монгол эмэгтэйчүүд хатадын гоёл чимэглэлийн тухай зарим нэг мэдээ үлджээ. Тухайлбал: *“Өгөөдэй хаан анд явж байтал нэг хүн хулуу авчирч өгөхөд, түүнд өгчих зүйл байгаагүй тул Мөгэ хатныхаа сувдтай ээмгийг түүнд өгсөн тухай, мөн садангийн нэг хүний хатан, хааны хатадын хувцас гоёл: сувд, бадмаараг чимэглэлийг ширтээд байсан тул наян мянган динараар авсан 12 авдар сувднаасаа түүний хормой, ханцуйд дүүргэн өгч явуулсан”* тухай, *“Хааны угсааны нэг гүнжийг бэр болгон явуулахад найман хүн дамнаж явах авдартай зүйлс ... сувд зүйрлэшгүй их байсан тухай, найранд ирсэн хүмүүст хундаганд сувд хийн өгч тараасан тухай”* (Рашид ад дин, 2002: 56, 64, 68) мэдээ байдаг.

XIII-XIV зууны монгол хатад эмэгтэйчүүд богтаг малгайныхаа оройн өмнө хэсэгт алтан саагаар хээ угалз хатгамалдан чимэглэж, алтан мөнгөн суурин дээр гоёмсог гэрэлтсэн том том дугуй сувд, бадмаараг, оюу болон тана, шүр, номин шигтгэн гоёдог байжээ. Хэлхсэн сувдан унжлага толгойдоо өмсөх нь дэлгэрмэл байсан бололтой. Хүзүү болон энгэртээ зүүлт зүүсэн зураг харагдахгүй. Харин Юань улсын хаадын хөрөгт хэлхсэн сувд эрх маягийн зүйлийг хүзүү, хоёр чихийг холбон энгэртээ зүүсэн нь сонирхолтой. Дээр дурьдсан эмэгтэйчүүдийн малгай, толгойн чимэглэл, зүүтгэл нь олон янз бөгөөд зэрэг дэв, эрх ямбыг илтгэдэг байсан ч болох талтай.

Юань улсын хатадын хөрөг зурагт тэдний *ээмэг* тодорхой дүрслэгдсэн нь хэв маяг, хэлбэр дүрсийн хувьд маш олон янз байжээ. Төгрөг дугуй, зууван дугуй, гархин, цэцгэн хэлбэртэй, шүр сувд, оюу, номин зэргийг шигтгэн, хоёр ба гурван салаа унжлагатай эсвэл том сувд, тана, номин шигтгээтэй байжээ. Харин хүзүүний зүүлт, бугуйвч, бөгж дүрслэгдсэнгүй. Эрдэмтэн Д.Наваан гуай Сүхбаатар аймгийн

Онгон сумын Таван толгой хэмээх газраас IX-XIV зууны үед холбогдох Монголын үеийн булшийг малтахад язгууртан эмэгтэйн оршуулга олдсон байна. Энд дагалдуулсан эд зүйлсийн дотор титэм маягийн алтан эдлэл, хос сүүжин ээмэг, алтан бөгж ... мөнгөн завъяа, хайч зэрэг эд зүйлс олджээ. Энгэр хавьцаа мөнгөн сувснууд бүхий ... мөчир хэлбэртэй жижиг ээмэг, ...бүсэлхий орчмоос жижиг алтан чимэглэлүүд олдсон нь тун сонин байна. Богтаг малгайн алтан чимэг нь Шидабал гэгээн хааны хатан Зэбэйн хөрөг дэх малгайн чимэглэлтэй төстэй гэж бичжээ (Наваан, 2006). Ийнхүү сурвалж бичиг, болон хатадын хөрөг зураг, археологийн дурсгалууд харилцан бие биеэ нөхвөрлөн монгол эмэгтэйчүүдийн гоёл чимэглэлийн олон зүйлийг тодруулж байна.

Хэдийгээр төрх байдал, нүүр царай, үс, хувцас хэрэглэл, гоёл чимэглэл нь тухайн үеийн эмэгтэйчүүдийг гаднаас нь үнэлсэн үнэлэлт болох талтай ч үүний нөгөө талд XIII-XIV зууны монголын эмэгтэйчүүдийн өрх гэр, нийгэмдээ гүйцэтгэсэн үүрэг, тэднийг үнэлэх тухайн үеийн нийгмийн үнэлэмжийн тухай асуудал байх бөгөөд энэ тухай “Монголын нууц товчоо ба эмэгтэйчүүд” (2008) номонд тодорхой дурсан болно.

### **НОМ ЗҮЙ**

- Арданжав Э., 1980. “Монголын нууц товчоо” сийрүүлэг тайлбар. Хөх хот. т. 100-101
- Баяр Д., 1990. Перс номын чимэглэл зурагт хадгалагдан үлдсэн дундад зууны үеийн монголын уран зургийн зарим мэдээ. *Studia historia*, 24. 9., УБ.
- Баяр Д., 1995. Монголчуудын гээг үсний тухай. “Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал”. Боть I. УБ. т. 252 - 255
- Баясах Ж., 2005. Их Монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр баримт бичиг. УБ., т. 92,
- Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл, 1985. (Асралт, Хөх –Өндөр нар) Хайлаар.
- Ванчигдаш Ч., 2008. Монгол нутаг дахь эртний хүн амын бие, бүтцийн үзүүлэлт. Магистрын ажил, МУИС.
- Викторова Л. Л., 1981. Монголы. Происхождение народа и истоки культуры. М.
- Карпини Дж. и Рубрук Г., 1957. Путешествие в восточные страны Плано Карпини и Вильгелма Рубрука. М.
- Гильом де Рубрук, 1988. Дорно этгээдэд зорчсон нь. УБ. т. 113-114
- Майский А., 2003. Орчин үеийн Монгол. УБ. т. 42
- Марко Поло, 1987. Орчлонгийн элдэв сонин. УБ.
- Монголын нууц товчоо, 2005. УБ.
- Наваан Д., Мөнхдэлгэр Ж., 2006. Таван толгойн 5-р булш ба Монголын язгууртны булш судлах асуудалд. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*, Vol. 2, №1 (254) January, 10-28
- Нямбуу Х., 2002. Монгол хувцасны түүх. УБ. т. 52-53
- Рашид ад дин, 1960. Сборник летописей, том II, М., стр.55
- Рашид ад дин, 2002. Судрын чуулган, II боть, УБ.
- Урангуа Ж., Энхцэцэг Д., 2000. Монгол хатад. УБ.
- Энхцэцэг Д., 2008. Монголын нууц товчоо ба эмэгтэйчүүд. УБ.
- Эрдэнэбаатар Д., Одонбаатар Ц., 2003. Нүүдэлчдийн бүс ба түүний хувьсалт өөрчлөлт. Археологи антропологи, угсаатны судлал. МУИС. ЭШБ. 40 (19) УБ., т. 129-132
- Эрдэнэбат У., 1997. Монголын нууц товчооны Алан Гоа эхийн домгийн учир. УБ.

*Эрдэнэбат У.*, 2006. Монгол эхнэрийн богтаг малгай. УБ.

*Chinzorig B.*, 2010. Battle Between Mongols on the Danube River Bank and Chrystians with Latin Language (from the ethno-historical point). Diploma thesis for MA. UB.

*Enkhtsetseg D.*, 2010. The seckret history of the Mongols and women. UB.

*Glastyan A.G.*, 1962. Armenian Sources about the Mongols. М.

***ДУНДАД ЗУУНЫ ҮЕИЙН МОНГОЛ ХАТАДЫН ХӨРӨГ***



